

«Их Алтайн их, дээд сургуулиудын ректоруудын зөвлөл» бүс хоорондын нэгдлийг үүсгэн байгуулах «Алтай - бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах Зөвлөлийн гишүүн - бүс нутгийн тэргүүлэх их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны Тунхаглал

Ард түмнүүд найрамдлаа бэхжүүлэх, ойртон нягтрах нэг үр ашигтай арга зам болох «Алтай - бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлийн (ОУЗЗ) үйл ажиллагаанд оролцогч бүс нутгуудын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагаа, хөрш ард түмнүүд соёлоо харилцан баяжуулж ирсэн түүхэн уламжлал дээр тулгуурлан, соёл, хүмүүнлэгийн салбарын хоёр болон олон талын харилцаанд цаашид дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн, «Алтай - бидний нийтийн гэр» ОУЗЗ-ийн 9-р хурлын (БНХАУ-ын ШУӨЗО-ны Үрэмч хот, 2010.08.30) 05 тоот шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр «Алтай» ОУЗЗ-ийн гишүүн их дээд сургуулиуд «Их Алтайн их, дээд сургуулиудын ректоруудын зөвлөл» хэмээх бүсийн нэгдсэн байгууллага байгуулах санал санаачлагыг дэмжин, түүнийг үүсгэн байгуулах үйл ажиллагаанд бүх талаар оролцоход бэлэн байгаагаа илэрхийлж дараах үүрэг хүлээж байна:

1. «Их Алтайн их, дээд сургуулиудын ректоруудын бүс хоорондын олон улсын зөвлөл» (цаашид Зөвлөл гэх)-ийн хүрээнд хуулийн этгээд болохгүйгээр хүчээ нэгтгэн, хамтран ажиллах;
2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлох:
 - бүс нутгийн их, дээд сургуулиудын хүчийг нэгтгэх, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, сургалтын явцыг цаашид боловсронгуй болгох, эрдэм шинжилгээг хөгжүүлэх, их, дээд сургуулиудын материал техникийн баазыг бэхжүүлэхэд чиглэсэн дээд боловсролын ерөнхий чиг хандлага, бодлогыг тодорхойлох зөвлөмж боловсруулах;
 - бүс нутгийн эдийн засаг, соёл, хөдөлмөрлөх хүчний нөөц, сургалтын байгууллагуудын зохистой байршил, их, дээд сургуулиудын бэлтгэж буй


мэргэжлийн чиглэлийг харгалзан үзсэн дээд болон төгсөлтийн дараах мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх санал боловсруулах, нийгмийн үйл ажиллагааны энэ хүрээг Их Алтайн бүс нутгийн инновацид чиглэсэн нийгмийн тогтвортой хөгжилд нөлөө үзүүлэхүйц бодит үйлдвэрлэх хүчин болгон хувиргах,;

- бүсийн эрдэм шинжилгээний цогц хөтөлбөр хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний хамтарсан лаборатори байгуулах, тэдгээрийн үр дүнг Их Алтайн бүсийн үйлдвэрлэл, нийгэм, эдийн засагт ашиглах, суралцагсдын эрдэмжилтийн чадавхийг хөгжүүлэх;
- олон улсын боловсролын системийн хүртээмжтэй, академик эрх чөлөөтэй, сургалтын явцыг судалгааны үйл ажиллагаатай салшгүй холбоотой байлгах уламжлал, суурь зарчмыг хадгалан хөгжүүлэх;
- олон улсын болон үндэсний байгууллага, сан, мэргэжлийн холбоо зэрэгтэй хамтран ажиллах;
- бүсийн их, дээд сургуулиудын худалдааны болон худалдааны бус байгууллагуудтай оюутнуудын практик бэлтгэл, төгсөгчдийн ажлын байрны хангамжийн асуудлаарх холбоо харилцааг бэхжүүлэх;
- их, дээд сургуулиудын мэргэжлийн чиг баримжаа олгох, авъяаслаг залуустай ажиллах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- их, дээд сургуулиудын олон улсын шууд харилцааг хөгжүүлэн бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- их, дээд сургуулиудын үйл ажиллагааны талаар үйлдвэрийн газар, албан газар, байгууллага, хувь хүмүүст зөвлөмж, мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлэх.

**«Алтай -бидний нийтийн гэр» олон улсын зохицуулах зөвлөлийн
оролцогчдын төлөөлөгчид**


Батлав

«Алтай -бидний нийтийн гэр» олон
улсын зохицуулах зөвлөлийн нарийн
бичгийн дарга




 - Ларин Б.В.

ОХУ-ын Алтайн хязгаар нутгийг төлөөлж


Улсын дээд мэргэжил олгох
боловсролын байгууллага «И.И.
Ползуновын нэрэмжит Алтайн
техникийн их сургууль»
Улсын дээд мэргэжил олгох
боловсролын байгууллага «Алтайн
улсын их сургууль»

Улсын дээд мэргэжил олгох
боловсролын байгууллага «Алтайн
эрүүл мэндийн их сургууль»
Улсын дээд мэргэжил олгох
боловсролын байгууллага «Алтайн
хөдөө аж ахуйн их сургууль»
Улсын дээд мэргэжил олгох
боловсролын байгууллага «Алтайн
боловсролын академи»

Алтай мәдениет және өнер
мемлекеттік академиясі



РГА СБ су және экологиялык
мәселелер институты

Казахстаны Дорнод Казакстан мужийг төлөөлж

С. Аманжоловын нэрэмжит Дорнод
Казакстаны улсын их сургууль




Д.Серікбаев атындағы Шығыс
Қазакстан мемлекеттік техникалык
университеті



Шөкәрім атындағы Семей
мемлекеттік университеті




«Қайнар» университеті, (Семей)



Оросын холбооны улсын Алтайн бүгд найрамдах улсыг төлөөлж

Улсын дээд мэргэжил олгох
боловсролын байгууллага «Горно-
Алтайскийн улсын их сургууль»




**Бүгд найрамдах Хятад ард улсын Шинжиан Уйгарын өөртөө засах
орныг төлөөлж**

✓ Шинжианы боловсролын газар




Шинжианы их сургууль



✓ Шихэцзын их сургууль




Шинжианы хөдөө аж ахуйн их
сургууль



Шинжианы цахилгаанмеханикийн
техник мэргэжлийн дээд сургууль




✓ Үрэмчийн ажил мэргэжлийн их
сургууль



Монгол улсын Ховд аймгийг төлөөлж

Ховд их сургууль



Монгол улсын Баян-өлгий аймгийг төлөөлж

Ховд их сургуулийн салбар сургууль